МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Нанжид Гонгор	Дугаар	L345
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Дэрэн сум
Төрсөн газар	Дэрэн сум	Төрсөн он	1921
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Жадамбын жас, Тэгшийн хийд, Бэлийн жас	Сүм хийдийн дугаар	ДУДР 088, ДУДР 087, ДУДР 090, ДУДР 092
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны8-рсарын 11	Ярилцлага авсан хүн	Жужа

Дундговь аймгийн Дэрэн сумын Жадамбын жас, Тэгшийн хийд, Бэлийн жас

Жужа: Жадамбын хийд хэдэн лам , хэдэн дугантай байсан бэ?

Нанжид Гонгор: 80-аад ламтай, таван дугантай байсан.

Жужа: Ямар ямар дуган?

Нанжид Гонгор: За цогчин, хайлан, Лхам сахиусны, багачуул хурдаг, дарь эхийн.

Жужа: Суварга байсан уу, хаанаа байсан?

Нанжид Гонгор: Нэг л суварга, баруун хойноо нэг км орчим зайд.

Жужа: Дан модон дуган уу?

Нанжид Гонгор: За дан модон дуган байсан.

Жужа: Лам нар ямар сууцанд байсан?

Нанжид Гонгор: Хийд дээрээ голдуу гэр оронтой, гэрт байсан. суурин бол хориод лам байсан. бусад нь хөдөө гэртэй байсан. Цаг цагийн хуралд ирж орно. Цогчин хайлан тогтмол байсан.

Жужа: Ойр орчимд тахилгат уул овоо бий юу?

Нанжид Гонгор: Хойно, тэр суварганы ард Цагаан магнай гэж овоо бий. Одоо ч тахидаг.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Жужа: Ойролцоо гол ус худаг байсан уу?

Нанжид Гонгор: Тэрүүхэн зүүн өмнө Баян бэлх гэж элбэг ус бий. Одоо ч бий.

Жужа: Ямар нэгэн нуур?

Нанжид Гонгор: Хийдийн наахантай 7, 8 ...5, 6 км-т хөндийд хар нуур бий.

Жужа: Хийдийн зүүнтэй том гантиг чулуунууд байна. Ямар учиртай чулуу вэ?

Нанжид Гонгор: Будагт гэдэг газар нэлээн улаан чулуутай уул. Тэндээс чулуу авчирч бутлаад усанд найруулж сүм дуган хашаа буддаг байсан.

Жужа: Тэр нэг хоёр том гантиг цагаан чулуу байна лээ?

Нанжид Гонгор: Аа тэр чинь цогчин дуганы үүдэнд байсан. Шүтдэг байсан. Одоо бүр босгоод босоо хүн шиг тавьчихсан, хадаг яндар зүүгээд, хаанаас авчирсныг мэдэхгүй.

Жужа: Хийдийн гол сахиус юу байсан?

Нанжид Гонгор: Лхам, Жамсран байсан. Тэгээд Чойжоо, намсрай гээд арван хангал бүх сахиусыг шүтнэ. Мундаг сайхан сахиусан бурхад байсан, сар болгон тахина. Дуган дотроо жижиг сүм байсан байхгүй юу, жижиг байшин гэсэн үг. Сахиусаа тахихаараа хаалгыг нь онгойлгоно. Бусад үед хаалгыг нь хаана. Их л гоё гэж хэлье дээ, их гоё байсан юм. Хорин есөн болгонд хангал тахина. Цагаан сарын арван зургаанд хоногт чоймпэрэл хурна, 16 хоног хурна. Хайлан 45 хоног хурна, намар. Хайланг гэлэг хүн л хурна.45 хоног, жирийн лам орохгүй. Яг 45 хоног хурна. Хөдөө гадаа явахгүй, тийм юм байхгүй.

Жужа: Хайлангаа тараад яах вэ?

Нанжид Гонгор: Ерөнхийдөө хуралдаа л хурна, цогчин энэ тэр гээд. Баян бэлх гэдэг тэр усан дээр чинь очиж том том асар майхан босгоод нэг том хурал хурна. Шинийн найманд магтаал, шинийн арван таванд ерөөл хурна, тогтмол. Бас жандаг хурна, хүний айлтгалын хурал. Бас Дүйнхорын дүчвжин гэж 16 хоног хурдаг мундаг том хурал хурна. Хойноос Богдын хүрээнээс лам ирж хурдаг. 3 жил хурсан юм, энд. Богд хааны шадар долоон хүний нэг нь гэнэ лээ. Цагаан сарын битүүнд цэдэр Лхам хурна, шөнөжингөө нойргүй хононо. Маргааш нь цэдэр гэж олон балин хийгээд өргөдөг. Тэгээд л чоймпэрэл хурж эхэлнэ.

Жужа: Майдар эргэдэг байсан уу?

Нанжид Гонгор: Үгүй, Тэгшийн хийдтэй хамтарч майдар эргэнэ.

Жужа: Ганжуур хурж байсан уу?

Нанжид Гонгор: Ганжуур хурна аа, улс үүрээд л тойроод л гороолоод л хийд болгон ганжууртай байсан юм шүү дээ. 120 боть баринтагтай том ном.

Жужа: Бурхан багшийн дүйчэн өдрөөр яах вэ?

Нанжид Гонгор: Хуралгүй яахав, мах идэхгүй, цагаан хоол иднэ.

Энхбаяр: Ямар нүгнээ тахих вэ?

Нанжид Гонгор: Дүвжирийн нүгнээ тахина. Маанийн нүгнээ тахина. Энэ үеэр их нарийн, нэг өдөр юу ч идэж уухгүй. Хүнтэй юм юу ч ярихгүй. Тэгээд л лам нарт чинь маргааш нь үйлчлэгч хүмүүс ирээд л жаарайсигдаа сайхан бараа болов уу гэж асуухад сайхан бараа боллоо гээд ам тайлна. Тэгээд шар тостой будаа, боов иднэ. Хүүхэд байхад их ядарна. өлсөж цангана, номоо л уншихаас хоол идэхгүй, хүнтэй ярихгүй. Их нарийн хурал шүү дээ. Бусад хийдүүд ч тэгдэг. Одоо ч Богдын хүрээнд хийдэг. Би ч ноднин Богдын хүрээнд очиж хэсэг байхдаа суусан.

Энхбаяр: Жинсрэг цутгадаг байсан уу?

Нанжид Гонгор: Цутгалгүй яахав.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Энхбаяр: Жил бүр үү?

Нанжид Гонгор: Яахав, жинсрэг цутгуулая гэсэн хүн байвал цутгана. Өөрсдөө жилд 1-2 удаа цутгана. Цаанаасаа том лам нар цутга гэж айлдвал цутгана, хамаагүй ч цутгахгүзй, лам болгон ч цутгахгүй. Эрдэмтэй том лам нар л хийнэ. Яггүй юм байсан юм байлгүй дээ. Бага байхад нэг их бургас мод овоолоод шар тос хийж гал түлээд л лам нар гоёчихсон тийм юм болдог байсан. би тийм хуралд орж байгаагүй, жаахан хүүхэд манз цавыг нь зөөгөөд л гүйж байсан.

Энхбаяр: Та хэдэн настайдаа лам болсон бэ?

Нанжид Гонгор: 8 настайдаа ном үзэж эхлээд лам болсон, 13-тай хурлын уншлага дуусгасан. Тэгээд гэцэл болж бүх уншлага хийх эрхтэй болж байгаа. Хайланд суух эрхтэй, тэгээд 17 хүртлээ 4 жил гаруй сууж байтал 18 хүрээгүй хүүхэд хуралд хурахгүй гээд 30-аад хүүхдийг шууд хар болгосон. Тэднийн нэг нь би. Би чинь 1921 онд төрсөн хүн.

Энхбаяр: Зоч лам байсан уу?

Нанжид Гонгор: Байхгүй, үгүй ээ ганц нэг хүн байсан юм. Тэд чинь хуралд ч суухгүй. Балдан, Банзар зоч, Гонгор зоч, Лодой зоч тэгээд бас нэг хоёр эмэгтэй хүн байсан санагдаж байна. Эднээс одоо Банзар Улаанбаатарт амьд байгаа, ерэн хдтэй өвгөн. Яасан айхтар юм асуудаг улс вэ, хаанаас ирсэн?

Жужа: Унгараас ирсэн. Хамба нь ямар хүн байсан бэ?

Нанжид Гонгор: Дэмбэрэл аграмба гэж их том лам Богдын хүрээнд суудаг байсан юм. Зуны эхээр ирээд зусч намаржаад буцдаг байсан. Манай эндхийн хүн. Дамдинсүрэн гэлэн, Найдан лам гэж том лам нар байсан. Дөрвөн гэсгүйтэй, цогчин гэсгүй, хайлан гэсгүй, багачууд дуганы гэсгүй, олон сахиус хариуцсан гэсгүй. Найман унзад байсан, 4 том унзад, 4 орлогч унзад.

Жужа: Энэ хийд хэдэн онд байгуулагдсан юм бэ, анх?

Нанжид Гонгор: Аа би мэдэхгүй. Би нас гүйцэж мэдэхгүй. Хүүхэд бүр бага байхад Жадамба дээр дуган барьж банай гээд л хэдэн хятад ирчихсэн модон дуган бариад л айл амьтан хүмүүс айраг ундаа, хоол цай зөөж гүйгээд л тэгж л байсан юм.

Жужа: Хэдэн жастай байсан бэ?

Нанжид Гонгор: Их жас, ерөөлийн жас, дарь эхийн жас, багачуулын жас, цогчин жас гэж 5 жастай байсан. Дан нярав, одоогоор бол даргатай. Гал зуух л байсан юм уу даа, манз цаваа тэндээ л хийдэг байсан.

Энхбаяр: Их жас, цогчин жас хоёр тусгай байсан юм уу?

Нанжид Гонгор: Тусдаа бие даасан 2 жас байсан юм .Ямар хурал хурах, аль дуган голлож хурах зэргээс шалтгаалан жасууд өөрсдийн чиглэлээр ажилладаг байсан.

Энхбаяр: Багачуулын дуган гэж яагаад нэрлэсэн юм бол?

Нанжид Гонгор: Залуучууд л голлоод санаачилж босгосон юм гэнэ лээ.Тэгээд ч багачуул голлон хурна. Залуухан гэсгүйтэй, залуухан лам нартай байсан.

Жужа: Зайсан даамал гэж байсан уу?

Нанжид Гонгор: Байгаагүй ээ, тэр чинь том том газар байсан байх аа.

Жужа: Та Тэгшийн хийдийн талаар хэр мэдэх вэ?

Нанжид Гонгор: Тааруу мэднэ ээ, бага сага. Хуралд нь очиж байсан юм. 200 гаруй ламтай, 14 унзадтай, манайхаас том газар.

Жужа: Хэдэн дугантай вэ?

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Нанжид Гонгор: 10-аад дугантай, тоосгон дугануудтай. Одоо туурь нь бий. Цогчин, мамба, хайлан, дарь эх гэх мэт цааш нь мэдэхгүй байна. Олон дугантай, их л хуралтай газар байсан. Манайхаас лам нар очиж хуралд нь сууна. Тэндээс манайд ирнэ. Хоорондоо ойрхон юм чинь нэг л ухаагийн ар өвөр хоёрт юм шүү дээ.

Жужа: Тэнд чойрын дуган байсан уу?

Нанжид Гонгор: Үгүй ээ, байгаагүй. Тэгш, Жадамба хоёр чинь чойргүй байсан. Чойрыг чинь тусгай газар...

Жужа: Бэлийн жасын тухай та мэдэх зүйлээ ярьж өгнө үү?

Нанжид Гонгор: 4 дугантай, 40, 50-иад ламтай хөөрхөн жижиг хуралтай газар байсан. Одоо Саруул бригадын тэнд туурь нь бий. Сүүлд нэг суварга босгосон.

Жужа: Ямар ямар дугантай байсан юм бэ?

Нанжид Гонгор: Одоо тэр дугануудын нэрийг би мэдэхгүй. 4 модон дуган л байсан. Одоо энэ сум дээр мэдэх хүн Дандиа өвгөн л бий. Тэр Бэлийн хуралд сууж байсан юм. Тэр өвгөн л сайн мэднэ.

Энхбаяр: Аймаг явчихсан эзгүй байна лээ.

Нанжид Гонгор: Жадамба, Тэгш хоёр чинь их холбоотой. Харин тэр Бэл чинь их тусгайдуу маягийн айл байсан юм. Манайхаас лам нар нэг их очдоггүй. Тэндээс ирдэггүй, Дэмбэрэл аграмба явуулдаггүй байсан юм уу, мэдэхгүй.

Энхбаяр: За хоёулаа Ждамба хийдийн бүдүүвч зургийг гаргах гээд оролдъё.

Нанжид Гонгор: За оролдъё. Энэ дээр үү, за энд цогчин байна гэж үзье. За баруун талд нь хайлан , багачуудын дуган нь цогчингоос жаахан хойно, тэр хоёрын голд нь дарь эхийн дуган, гэр хэлбэрийн модон дуган байсан. Хайлангийн урд нь лхамын дуган, тэгээд хайлангийн ард цагаан магнай овоо байдаг. Ерөнхий байдал энэ.

Энхбаяр: Суварга нь яг хаанаа байсан юм бэ?

Нанжид Гонгор: Овооны зүүн өмнө байсан, сайхан суварга байсан. Одоо энэ суваргыг чинь саяхан босгосон юм.

Энхбаяр: Тэгшийн хийдийн дуган ямар дуган байсан юм бэ?

Нанжид Гонгор: Шавар тоосгон дуган л голдуу байсан, модон дуган байгаагүй. Лам нар нь модон байшинд суудаг байсан. Гол урдаа цогчин, цогчингийнхоо хоёр талд залгаатай хоёр дуган байсан. Ингээд урдаа үндсэндээ залгаа 3 дуган, гэхдээ хаалга нь тус тусдаа. Цогчингийнх урдаасаа, нөгөө 2 дуган нь хажуугаасаа хаалгатай. Ингээд энэ залгаа 3 дуганы араар нэг эгнээ шахуу 4, 5 дуган байсан юм. Одоо тэнд босгосон суваргыг чинь гол цогчин дуганы туурин дээр босгосон юм гэнэ лээ. Бас нэг лам өвгөн нэг суварга босгосон. Тэгшид одоо 3 суварга босгосон байх. Цогчины урд утасны мод шиг нэг өндөр багана байсан. Дээрээ бурхантай л гэдэг байсан. Ямар харагдах биш, их өндөр шон. Хийдийг нурааж устгахад тэр багана үлдсэн байсан. Энэ шонгоор яахав л гэж бодоо биз дээ.

Энхбаяр: Өөр хийд жас энэ хавьд байсан уу?

Нанжид Гонгор: Байхгүй ээ, аймгаас нааш бол байсан шүү дээ. Их жас, Үйзэн ахай ч гэж байсан. Энэ хавьдаа бол Жадамба, Тэгш хоёр л байсан.

Энхбаяр: Тэгшийн гурван суваргыг хэзээ босгосон юм бэ?

Нанжид Гонгор: Анхныхыг 4 жилийн өмнө баг сумаараа хамтарч босгосон юм. Дараачийнхыг 2 жилийн өмнө нэг өвгөн лам босгосон, би түрүүн хэлсэн. Сүүлчийнхийг ноднин нутгийн нэг айл өрх ах дүүсээрээ хамтарч босгосон юм.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Энхбаяр: Сумын төвийн шинэ хийд хэдэн онд байгуулагдсан юм бэ?

Нанжид Гонгор: Есөн жил болж байна.

Энхбаяр: Анх хэдэн ламтай хурал эхэлсэн?

Нанжид Гонгор: Хорин хэдэн ламтай хурал эхэлсэн. Одоо байхгүй ээ.

Энхбаяр: Бүгд настай лам нар байсан уу?

Нанжид Гонгор: Тэр үед 70, 80-тай л өвгөчүүд байсан. Дор нь хэдэн залуучууд байсан.

Энхбаяр: Анхны хамба нь ямар хүн байв?

Нанжид Гонгор: Хамба нь Чимэддорж гэж лам байсан. Ерэн хэд хүрч өнгөрсөн. Гэсгүй нь Даш гэж одоо амьд ерэн хэд хүрч байгаа өвгөн бий. Багачуул нь голдуу хот руу явсан. Дашчойлин , Нанжид Гонгорчойлин дацангуудад хурж байгаа.

Энхбаяр: Хэзээнээс ингээд хурал зогссон бэ?

Нанжид Гонгор: Уржнангаас хурахаа больж эзгүйрсэн. Би ганцаараа өвчтэй болсон хүн босч чадахгүй болохоор яахав дээ. Харин энэ хашаа байшин доторх юмыг энэ сумын захиргаа сайн харж хаанддаг бололтой юм.

Энхбаяр: Энэ суварга ямар учиртай вэ?

Нанжид Гонгор: Дандиа гэдэг хүн 2, 3 жилийн өмнө босгосон юм. Тэднийнхний нэг том лам Дэлгэрийн Чойрт байж байгаад таалал болсон юм. Тэгээд босгосон юм.

Энхбаяр: Энэ хийдийн гол сахиус нь юу вэ?

Нанжид Гонгор: Гол сахиус нь Лхам, гэхдээ Жамсран, Чойжоо, Гомбо сахиусуудыг тахина.

Энхбаяр: За таньд баярлалаа.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон